


**Үйл явдлыг учир
шалтгааны уялдаа
холбоотой бичих**



Монгол хэл, 6-р анги, Хичээл № 4

1

Болж буй үйл явдал бүхэн ямар нэг шалтгааны улмаас бий болдог

2

Учир шалтгаанаас үүссэн үйл явдлууд хоорондоо холбоо хамааралтай байдаг.

3

Ямар учраас, яагаад,

4

Зангилаа буюу учир шалтгаанаас дараагийн үйл явдал өрнөнө.

Мятав “ Хонь салхидаад Хэцүү цүнхээлд үйчих вий, юмыг яаж мэдэх вэ?” гэсээр нуурын хойд ухаа дээгүүр гарч иржээ. Гэтэл бачимдсан хүний муухай орилох дуу гарч гэнэ. Тогтож харвал, нуурын усанд нэг хүн орчихсон үе үе шовхийн, сарвалзаж байгаа үзэгдлээ. Мятав нэг мэдэхнээ нуурын эрэг дээр ирчихсэн “ Одоо яанаа сүйд боллоо. Нуур луу орчихоор хамт өнгөрчих, гарт нь бариулчих гэхээр юу ч байдаггүй” гэж гаслан зогсож байв...

Үйл явдал өрнөх шалтгаан болж буй өгүүлбэрийг олоорой.


Гэтэл бачимдсан хүний муухай орилох дуу гарч гэнэ.

Тогтож харвал, нуурын усанд нэг хүн орчихсон үе үе шовхийн, сарвалзаж байгаа үзэгдлээ.

“ Яанаа, өнгөрчихлөө л дөө” гэж харамсан ийш тийшээ хартал бөөр алаг хүрэн бяруу нь оодгонон сүүл хатгасаар айсуйг үзэнгүүт:


- Тэгдэг хэрэг, болдог арга! гэж дуу алдан бярууг амдлаа. Ялаа шумуулд хөөгдөн ухаан жолоогүй яваа бярууг ойртоод ирэхээр нь ухасхийн сүүлдэж барьж аваад тэврэн нуур луу гүйв. Нуурын эрэг дээр ирж, нөгөө хүний ил гарч ирэхийг отож байснаа байдаг чадлаа шавхан, бярууг нуурын тэг дунд чулуудчихлаа. Палхийх сүртэй чимээ гарч, Мятав цалгисан усны хүчит давалгаанд цохигдон, ар тийшээ саван унажээ. \ 3 \

Мятавын хийсэн гол үйлийг ялгая



Долгио намдахаар эргэн тойрноо харсан чинь нөгөө хүн тэртээ эргийн шаргал элсэн дээр хэвтээ харагдлаа. Очтол нөгөө хүн амьсгаа авч жаахан уужраад:

- Ус, элс хоёрт үхэх шахлаа. Юу ч болов доо. Усанд сарваганаж явтал минь нэг хүн том алаг юм чулуудчих шиг болсон. Тэгсэн чинь ус хүчтэй палхийгээд, би түүнээс үүссэн хүчтэй долгионд цохигдон шидэгдэж, яаж ч чадалгүй элс рүү шаачхаад, бүтэж үхэх шахлаа гэхэд:
- Арай хүчтэй шидчихсэн юм болов уу даа. За яамай, яамай. Эрдэнэт хүний амь л мэнд гарсан бол болох нь тэр! гэж Мятав олзуурхан баярлаж суужээ. \ 4 \



Үйл явдал дарааллан болж байна

Хүний золионд амь алдах шахсан бярууны хошуу үе үе цухалзан явсаар, нуурын эрэг рүү огло харайн гарч, ус шилгээгээд “Ингэж сэрүүцүүлдэг бол ч аюултай юм байна” гэсэн янзтай эзэн рүүгээ харж байснаа ижлээ үгүйлэх мэт мөөрөн, гэрийн зүг шогшиход Мятав:

- **Ингэх л ёстой сон. Овоо шүү, бөөр алаг минь. Монгол үхрийн эрдмийг ёстой нэг үзүүлж чадлаа даа гэж бахдан хайрлажээ.**

Ш. Цэнд-Аюуш

Монголын уран зохиолын дээжис, 102-р боть, 2008

Үйл явдлын үр дүнг илэрхийлсэн өгүүлбэрийг олоорой

Ингэх л ёстой сон. Овоо шүү, бөөр алаг минь.

Монгол үхрийн эрдмийг ёстой нэг үзүүлж чадлаа даа гэж бахдан хайрлажээ.

Эхлэл хэсэг

гол хэсэг

төгсгөл

Үйл явдлын
орчны
дүрслэл

Үйл явдал
өрнөх

Үйл явдал
өрнөх
шалтгаан

Үйл явдлын
үр дүн



Эхлэл **хэсэг**

гол хэсэг

төгсгөл

Гэр бүлээрээ аялалд явах үед болсон дүүгийнхээ хөгжилтэй явдлыг бичихээр шийдлээ

Үйл явдал

- Хаана \ орчны дүрслэл \
- хэзээ болсон \ цагийн дүрслэл\
- Хэн хэнтэй хамт байсан
- Гол дүрийн тухай
- Түүх өгүүлэх
- Уншигчаас асуулт асуух
- **Үйл явдал өрнөх болсон шалтгааныг өгүүлэх**

Үйл явдал

- Сонирхолтой, хөгжилтэй үйл явдлаа дарааллаар нь өрнүүлэн бичих
- Оролцсон дүрүүдийн хандлага, яаж оролцсон
- Баримт жишээ, харилцан яриа, дүрслэлээр дэлгэрүүлэх

Үйл явдал

- Сургамжтай санаагаар дүгнэх
- Үр дүнг бичих
- Асуудлаар төгсгөх
- Гол дүрийн сайн тал, зөв дадал хэвшил, зан чанар зэргээр дүгнэж төгсгөх

Бичихээ төлөвлөө

Санаанд орсноо холбоо үг, богино өгүүлбэрээр ноороглон бичээрэй.

Хэзээ

- Зуны өглөө,
- цэлмэг тэнгэр,
- бүртийх ч үүлгүй,

Хаана?

- Архангай аймгийн Батцэнгэл сумаас зүүн тийш 30 км,
- Улаанбаатар Хан-Уул дүүрэг,

Эхлэл хэсэг

- Ээж минь биеийн тамирын хувцас, саравчтай малгай өмсөв,
- Аав нимгэн цамцан дээрээ хүрэм, биеийн тамирын өмд,
- ах цамц, бас л биеийн тамирын өмд өмсөв. Би биеийн тамирын хослолоо өмсөв,
- Дүү минь эрээн алаг цамц, цагаан малгай өмсөв
- **гэрээсээ гарлаа, баяр хөөрөөр дүүрэн, сэтгэл догдлон, бүх хүний царай гэрэлтэнэ, Дүү минь бүхнээс баяр хөөртэй харагдана, Тэр одоо 2 настай**

Гол хэсэг

Дүү бид хоёр хөтлөлцөн гүйлээ.....

Ээжийн бүх болгоомжлол алга болсон
мэт.....

хөөе уналаа, аваарай, босгоорой гээд л байдаг хүн.....Бид хоёрын очсон тэр хэсэгхэн газар айл байгаад сая нүүсэн бололтой.....Хонины хоргол байна.....дүү минь нэг мэдэхэд үрлэн чихэр гээд хашхиран түүгээд л ам руугаа хийгээд байлаа,би инээдээ барьж дийлсэнгүй, амнаас нь хорголыг нь гаргалаа.....ээж бас инээнэ, аав нүдээрээ инээмсэглэнэ,,,,,,ах дүүг өхөөрдөн тэвэрнэ, муухай амттай байсан бололтой учиргүй ярвайна.....сөөсгөр даахь нь нарны гэрэлд шаргалтан харагдана.....Тожгор гартаа хэдэн хонины хоргол бариад май май гэж хүн бүхэн лүү сарвайна, Бид инээгээд л ,,.....дүү тойрч гүйгээд л.....цэцгэн дунд эрх таваараа гүйнэ.....Би гутлаа тайлан гүйлээ.....Хөлний улнаас гижигдэнэ.....Ямар нэг зөөлөн хивсэн дээр байгаа мэт мэдрэмж төрнө.

ТӨГСГӨЛ ХЭСЭГ

Хэлд ороогүй ч хөлд орсон дүү минь өхөөрдөм,.....манай гэр бүлийн халуу дулаан уур амьсгалыг бий болгон.....түүний хийж буйг харсан хэн бүхний нүүрэнд өөрийн эрхгүй инээмсэглэл тодорно.....
.....хоёр настай хүүхдийн үйл санаатай санамсаргүй аль нь юм бол,,,би багадаа ямар байсан бол хурдхан л ээжээс асуумаар санагдаад майхан руугаа яарлаа.....тэртээ алсад тэнгэрийн одод гялалзана.....ямар сайхан намуун дулаахан орой вэ?.....сэтгэл санаа тайван амгалан.....цаашид утга учиртай зорилготой амьдар гээд хэн нэгэн хэлээд ч байх шиг.....дүүгийн явдлыг санаад нэг л хөөр догдлолоор дүүрээд байх шиг.....

Гэртээ

1. Засан сайжруулаад бичиж болно
2. Шинээр төлөвлөн бичиж болно
3. Сурах бичгийн хуудас 26- 28-р хуудасны хичээлийг үзээрэй.